

ЗДТГАЗРЫН ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хуралдааныг 2024 оны 6 дугаар сарын 11-ны өдөр 09<sup>50</sup> минуданд Багийн засаг дарга нарийн өрөөнд Өмч хамгаалах зөвлөлийн дарга Ю.Туяамаа Нарийн бичиг Ө.Уранбилэг Гишүүд Ч.Урантуяа О.Ганбаатар нар оролцолоо.

Хуралдаанд дараах асуудалыг хэлэлцэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Засаг даргын Тамгын газрын сольсон цонхонд үнэ ханш тогтоож худалдан борлуулах талаар хэлэлцэнэ.

СОНССОН НЬ:

Нярав Ч.Урантуяа: Уг цонх нь 2008 онд ашиглалтанд орж 16 жил ашигласан ашиглалтын байдал муудаж дулаан алдагталтай завсраар нь салхи шороо орж барив нь ажиллагаагүй болсон тул худалдан борлуулах саналтай. Нийт 19 цонх сольсоноос 4 цонх нь хагархай байгаа үүнийг актлах үлдсэн 15 цонхыг нь үнэ ханш тогтоож борлуулах саналтай байна.

Ю.Туяамаа: Улаанбаатар хотод гайгүй шиг аklагдсан цонхнууд 70-80 мянган төгрөгийн үнэтэй байдаг. Тиймээс ийм удаан хэрэглэгдсэн чанар байдлаа алдсан зэргээс нэг бүрийн үнийг нь 50,000 төгрөгөөр хагарсан 4ш цонхыг 10,000-15,000 төгрөгөөр худалдан борлуулах саналтай байна.

Ө.Уранбилэг: Ийм удаан ашиглагдсан олон жил болсон цонхыг 40,000-50,000 төгрөгөөр үнэ тогтоож худалдан борлуулах саналтай байна. Хагарсан 4ш цонхыг 10,000-20,000 төгрөгөөр худалдан борлуулах саналтай байна.

О.Ганбаатар: Саналуудыг дэмжиж байна 50,000-60,000 төгрөгөөр худалдан борлуулах саналтай байна.

Ч.Урантуяа: Хашаат багийн төвийн 4 модон цонхыг энэ хуучин вакум цонхоор солих мөн ЗДТГазрын цайны газрын хагархай цонхыг хуучин вакум цонхоор солих саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн саналаар 4ш хагарсан цонхыг нь 10,000 төгрөгөөр 4ш цонхыг нь хашаат багийн төвийн цонхыг солиход мөн 1ш цонхыг нь ЗДТГ-ын цайны газрын буудлын цонхыг солих Үлдсэн 10ш цонхыг нь нэг бүрийн үнийг нь 50,000 төгрөгөөр худалдан борлуулж нийт 540,000 төгрөгийг 100080000960 дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэв.

ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА :  Ю.ТУЯАМАА

НАРИЙН БИЧИГ :  Ч.УРАНБИЛЭГ

ГИШҮҮД :  Ч.УРАНТУЯА

О.ГАНБААТАР